

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

АГУУЛГА

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар тодруулга	7
2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл	7
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	7
3. Аудит хийсэн санхүүгийн тайлан	8
3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	8
3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	8
3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тохируулгын тайлан	10

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
НББ	Нягтлан бодох бүртгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АХБ	Азийн хөгжлийн банк



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЗҮҮН ӨМНӨД ГОВИЙН ХОТ
БАЙГУУЛАЛТ, ХИЛИЙН ОЙРОЛЦОО
СУУРИН ГАЗРУУДЫН ХӨГЖЛИЙН
L3713-MON НЭМЭЛТ
САНХҮҮЖИЛТИЙН ТӨСӨЛ II" -ИЙН
ЗОХИЦУУЛАГЧ Б.ОЮУН ТАНАА

2020.04.15 № 06/1135
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн L3713-MON нэмэлт санхүүжилтийн төсөл II”-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн L3713-MON нэмэлт санхүүжилтийн төсөл II”-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайлан материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, үнэн, зөв бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн L3713-MON нэмэлт санхүүжилтийн төсөл II”-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

“Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн L3713-MON нэмэлт санхүүжилтийн төсөл II”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг төслийн зохицуулагч Б.Оюун танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн L3713-MON нэмэлт санхүүжилтийн төсөл II”-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн L3713-MON нэмэлт санхүүжилтийн төсөл II”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн L3713-MON нэмэлт санхүүжилтийн төсөл II”-ийн зохицуулагч нь санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 3 дугаар сарын 5-аас 2020 оны 3 дугаар сарын 27-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “**Грант Торнтон аудит**” ХХК-ийн ахлах аудитор Л.Болорцэцэг, аудитор Ш.Оюунчимэг, туслах аудитор Э.Мэндсайхан нар Үндэсний аудитын газрын захиалгаар хариуцаж хэрэгжүүлэв.

“Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн L3713-MON нэмэлт санхүүжилтийн төсөл II”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Грант Торнтон аудит” ХХК-д 2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин

Төслийн үндсэн зорилго нь бохир ус цэвэрлэх байгууламжийн шинэлэг технологи ашигласнаар байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл багасч, орон нутгийн оршин суугчдын эрүүл ахуй, орчны стандартыг дээшлүүлэх юм. Энэхүү зээлийн төслийн хүрээнд төсөлд хамрагдсан орон нутгийн нийтийн аж ахуйн байгууллагуудын бүтцийн шинэчлэл, чадавхи бэхжүүлэх үйл ажиллагаа хийгдэнэ.

Төслийн хүрээнд Хөвсгөл, Булган, Дундговь, Хэнтий, Сүхбаатар аймгийн төвүүдэд био өнгөр тогтоогч бүхий идэвхжүүлсэн лагийн технологи ашигласан, орчин үеийн, үр ашигтай цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлыг 2019-2021 онуудад барьж ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна.

Азийн хөгжлийн банк нь энэхүү зээлийн гэрээ болон Азийн Хөгжлийн банк ба Аймгийн Захиргаадын хооронд байгуулсан гэрээний дагуу Азийн хөгжлийн банкны энгийн хөрөнгийн нөөцөөс 20,000.0 мянган ам доллартай тэнцэх зээл олгохыг зөвшөөрч Азийн Хөгжлийн банкны захирлуудын зөвлөл 2018 оны 9 дүгээр сарын 26-нд баталсан.

Төсөл нь Монгол Улс болон Азийн хөгжлийн банк (АХБ) хооронд 2016 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр байгуулсан L3388-MON төслийн нэмэлт санхүүжилтийн зээлийн гэрээ (Олон улсын гэрээ)-ний ажлыг үргэлжлүүлэн “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн L3713-MON нэмэлт санхүүжилтийн төсөл II”-ийг хэрэгжүүлэхээр Монгол Улс болон Азийн хөгжлийн банкны хооронд 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдөр MON 42184 тоот зээлийн гэрээг 19 жилийн хугацаатайгаар байгуулсан байна.

Тус төслийн нийт өртөг Азийн хөгжлийн банкнаас 20,000.0 мянган ам.доллар, Монгол Улсын Засгийн Газраас 1,750.0 мянган ам.доллар нийт 21,750.0 мянган ам.доллар байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

“Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн L3713-MON нэмэлт санхүүжилтийн төсөл II”-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

“Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн L3713-MON нэмэлт санхүүжилтийн төсөл II” нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн програм хангамж ашиглдаггүй, хэрэглээний “Microsoft Excel” программ хангамж ашигладаг байна.

Төслийн удирдах нэгжийн үйл ажиллагааг Сангийн Сайдын 2015 оны 7 дугаар сарын 10-ны 196 дугаар тушаалаар удирдан чиглүүлж байна.

“Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн L3713-MON нэмэлт санхүүжилтийн төсөл II”-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “Үр нөлөөгүй” гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн L3713-MON нэмэлт санхүүжилтийн төсөл II”-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төслийн гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайланд холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 2 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 59,845.0 мянган төгрөгөөс тооцон 598.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг өөрчлөөгүй.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн L3713-MON нэмэлт санхүүжилтийн төсөл II”-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлтүүд дараах байдалтай байна

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	1,723,422.6	(1,723,422.6)
Урьдчилж төлсөн зардал	-	2,676,405.1	(2,676,405.1)
Бусад эргэлтийн хөрөнгө	-	10,076,820.1	(10,076,820.1)
Нийт хөрөнгө	-	14,476,648.0	(14,476,648.0)
Өр төлбөр	-	506,614.3	(506,614.3)
Хуримтлагдсан үр дүн	-	13,970,033.4	(13,970,033.4)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	-	14,476,648.0	(14,476,648.0)

Энэхүү төсөл нь тайлант онд шинээр хэрэгжүүлж байгаа тул эхний үлдэгдэл байхгүй. Тайлант онд урьдчилж төлсөн зардал, бусад хөрөнгө, өр төлбөр дансанд материаллаг үлдэгдэлтэй байна. Тухайлбал:

Урьдчилж төлсөн зардал дансанд Хэнтий, Хөвсгөл аймгийн төвийн цэвэрлэх байгууламж барихаар гэрээ байгуулсан “Комфорт импэкс” ХХК, “Набсан” ХХК, “Эс энд Эй трейд” ХХК-д шилжүүлсэн гэрээт ажлын урьдчилгаа төлбөр нийт 2,676,405.1 мянган төгрөгийг бүртгэсэн байна.

Бусад хөрөнгө дансанд Булган, Хэнтий, Хөвсгөл аймгуудад барьж буй цэвэрлэх байгууламжуудын ажлын гүйцэтгэл нийт 10,076,820.1 мянган төгрөгийг хуримтлуулан бүртгэж байна.

Өр төлбөр дансанд Булган, Хэнтий, Хөвсгөл аймгуудад барих цэвэрлэх байгууламжийн гэрээт ажлын барьцаа төлбөр 506,614.4 мянган төгрөгийг бүртгэсэн байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн L3713-MON нэмэлт санхүүжилтийн төсөл II”-ийг хэрэгжүүлэхэд зориулан нийт 11,258,000.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 11,257,608.0 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагдсан байна.

Нийт зардлыг Азийн Хөгжлийн банкнаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Төслийн мөнгөн хөрөнгөнд гүйцэтгэлээр 12,941,682.3 мянган төгрөгийг Азийн хөгжлийн банкнаас авч, харилцах дансны хүүгийн орлого 9,959.1 мянган төгрөг, бусад орлого 14,152.4 мянган төгрөг, валютын ханшийн зөрүүний хэрэгжсэн олз 25,411.2 мянган төгрөг нийт 12,965,794.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 11,257,823.3 мянган төгрөгийг зарцуулж, 9,959.1 мянган төгрөгийг төвлөрүүлж, 1,723,422.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 3.5-д харуулав.

2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 2 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 3 эрсдэл тодорхойлж нийт 8 горим сорил хэрэгжүүллээ.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал гараагүй.

2.12. Шилэн дансны мэдээлэл

“Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн L3713-MON нэмэлт санхүүжилтийн төсөл II”-ийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

“Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн L3713-MON нэмэлт санхүүжилтийн төсөл II” нь тайлант 2019 онд үйл ажиллагаа эхэлсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн L3713-MON нэмэлт санхүүжилтийн төсөл II”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБООУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн L3713-MON нэмэлт санхүүжилтийн төсөл II”-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНБООУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Аудит хийсэн санхүүгийн тайлан

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөг)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	-	14,476,647,828.70
31	Мөнгөн хөрөнгө	-	1,723,422,564.42
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	1,723,422,564.42
3121	Төгрөг	-	292,131,455.72
31211	Төрийн сангийн харилцах		292,131,455.72
3122	Гадаад валют	-	1,431,291,108.70
31223	Арилжааны банк дахь харилцах		1,431,291,108.70
34	Урьдчилгаа	-	2,676,405,140.67
34600	Урьдчилж гарсан зардал		2,676,405,140.67
36	Нөөцийн бараа	-	10,076,820,123.61
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/		10,076,820,123.61
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	-	14,476,647,828.70
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	506,614,436.83
41	Богино хугацаат өр төлбөр	-	506,614,436.83
4136	Бусад өглөг	-	506,614,436.83
41361	Байгууллагад төлөх өглөг		506,614,436.83
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-	13,970,033,391.86
51	Засгийн газрын хувь оролцоо	-	13,970,033,391.86
512	Хуримтлагдсан үр дүн	-	13,970,033,391.86
51220	Тайлант үеийн үр дүн		13,970,033,391.86
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-	14,476,647,828.70

3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөг)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	-	13,954,796,736.61
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	13,954,796,736.61
120	Нийтлэг татварын бус орлого	-	13,954,796,736.61
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		13,940,644,336.61
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		9,959,074.88
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих		12,941,682,290.50
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		989,002,971.23
120009	Бусад орлого		14,152,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	10,174,548.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	10,174,548.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	215,473.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	215,473.20
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		215,473.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	9,959,074.88
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	9,959,074.88
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		9,959,074.88
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-	13,944,622,188.53
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	25,411,203.33
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз		25,411,203.33
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	25,411,203.33
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-	13,970,033,391.86

3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-3А

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөг)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	-	12,965,793,765.38
12	Татварын бус орлого	-	12,965,793,765.38
120	Нийтлэг татварын бус орлого	-	12,965,793,765.38
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	12,951,641,365.38
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		9,959,074.88
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих		12,941,682,290.50
120009	Бусад орлого		14,152,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	10,174,548.08
21	Урсгал зардал	-	10,174,548.08
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	-	215,473.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	215,473.20
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		215,473.20
213	Урсгал шилжүүлэг	-	9,959,074.88
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг		9,959,074.88
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	12,955,619,217.30
23	Эргэж төлөгдөх төлбөрийн хассан зээл	-	11,257,607,856.21
23001	Эргэж төлөгдөх зээл	-	11,257,607,856.21
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	-	(25,411,203.33)
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз		(25,411,203.33)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	(11,232,196,652.90)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	1,723,422,564.42
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,723,422,564.42

3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөг)

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	13,970,033,391.86		13,970,033,391.86
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,970,033,391.86	-	13,970,033,391.86

3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөг)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт/ хэмнэлт	%
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	11,258,000,000.00	11,257,607,856.21	392,143.79	100
23	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн	11,258,000,000.00	11,257,607,856.21	392,143.79	100
230001	Эргэж төлөгдөх зээл	11,258,000,000.00	11,257,607,856.21	392,143.79	100
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	11,258,000,000.00	12,941,682,290.50	1,683,682,290.50	115
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	11,258,000,000.00	12,941,682,290.50	1,683,682,290.50	115
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1,684,074,434.30		

3.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тохируулгын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөг)

Код	ДАНСНЫ НЭР	Тайлант оны дүн
I	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-
II	МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН НИЙТ ОРЛОГО	
	Орлогын тохируулга:	40,911,203.33
	Банкны хүүгийн орлого	-
	Тендерийн орлого	15,500,000.00
	Валютын ханшийн зөрүү	25,411,203.33
III	ТОХИРУУЛСАН ОРЛОГЫН ДҮН	40,911,203.33
IV	МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН НИЙТ ЗАРЛАГА	
	Зарлагын тохируулга:	1,563,073.20
	Тендер, ажлын байрны зарын төлбөр	-
	Банкны үйлчилгээний хураамж	215,473.20
	Тендерийн зардал	1,347,600.00
V	ТОХИРУУЛСАН ЗАРЛАГЫН ДҮН	1,563,073.20
	Эцсийн үлдэгдлээс тохируулсан орлого	-
VIII	ТОХИРУУЛГЫН ДАНСНЫ ҮЛДЭГДЭЛ (III-V-VI)	39,348,130.13
IX	Тохируулсан орлого зарлагаас үлдсэн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл (III-IV)	39,348,130.13

ТЭМДЭГЛЭЛ

A series of 28 horizontal dotted lines spanning the width of the page, providing a template for writing.